

**ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН 2024 ОНЫ АВЛИГЫН
ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

д/д	Зорилт, Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилт
<i>Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</i>					
1.1.	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас, б/сошиал сувгууд, в/дотоод сүлжээ, г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; -Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; -Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Жилдээ	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг тогтмол байршуулж, олон нийтэд сурталчилсан байна.	Тайлант хугацаанд АТГ-аас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн шторк, баннер, теле зохиомж, контент зэрэг мэдээллийг эхний хагас жилд 33, дараагийн хагас жилд 23, нийт 56 нэр төрөл бүхий мэдээллийг байгууллагын цахим хуудас болон нийгмийн сүлжээнд байршуулан сурталчилав. /Хавсралт №1 Сүүлийн хагас жилийн Нотломжийг хавсаргав – нийт 8 хуудас/
1.2.	Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх.	Жилдээ	Нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан байна.	2024.05.04-06-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Баянгол сум, Богд сумын малчин болон мал бүхий иргэдэд малын индексжүүлсэн даатгал /МИД/-ыг сурталчилан таниулахад чиглэгдсэн өдөрлөг зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээний үеэр МИД-ын тухай хуулийн хэрэгжилт болон даатгалын үйлчилгээний

					талаарх санал хүсэлтийг иргэдээс авав. 2024.12.09-ны өдөр Сангийн Яамны санаачлагаар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран Төрийн ордны Их Монгол танхимд "Зудын эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлэхэд малын индексжүүлсэн даатгалын оролцоо" малчдын зөвлөгөөн зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 21 аймгийн малчид болон төрийн байгууллагын төлөөлөл оролцсон бөгөөд малын индексжүүлсэн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчны өөрчлөлтийг танилцуулж, МИД-ын үйл ажиллагаа, хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдох санал хүсэлтээ цахимаар 191 оролцогч, бичгээр 12 оролцогч саналаа тус тус өглөө. Асуумжийн үр дүнг дараах цахим хаягаар харах боломжтой. https://docs.google.com/forms/d/19d0z7RjIEzjantg3YpphezyY
--	--	--	--	--	--

					y4JTtu-tmnC_ZHrLBc/edit#responses
1.3.	Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах	- Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; -Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Жилдээ	Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр эрхлэн гаргадаг гарын авлага, хэвлэмэл материалд авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилна.	“Үндэсний Давхар Даатгал” ХК нь Малын Индексжүүлсэн Даатгалын үйл ажиллагааг сурталчилах, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, малчин өрхийг мэдээллээр хангах чиглэлээр “Эрсдэлгүй ирээдүйн төлөө” сонинг эрхлэн гаргадаг бөгөөд 2024 оны 4 дүгээр сард 51,000 ширхэг нийтлэгдсэн тус хэвлэлд авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилж хөдөө, орон нутагт хүргүүлэн түгээсэн.
Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх					
2.1.	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	-Салбар бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; -Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Үр дүнг тооцож, тайлагнасан байх	Жилдээ	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн байна.	Даатгалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагууд: 1. “Монголын даатгалын холбоо” НҮТББ 2. “Монголын даатгалын зах зээлийн холбоо” НҮТББ Тус байгууллагуудтай иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэх, даатгалын салбарын хуулийн хэрэгжилтийг хангах, даатгалын мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулсан

					эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.
2.2	Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	-2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, /гүйцэтгэл/-ийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх; -Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, /гүйцэтгэл/-тэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах; - Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх.	Жилдээ	Төсөл арга хэмжээний талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлсэн байна.	2024 оны төсөвт төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээ тусгагдаагүй. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн “2024 оны үйл ажиллагааны төсөв” болон “2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө”-г шилэн дансанд байршуулж, компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлсэн.
2.3.	Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	-Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; -Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; -Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэлд холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд	Жилдээ	Ирүүлсэн гомдол, мэдээлэлд тулгуурлан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.	Тайлант хугацаанд иргэд, олон нийтээс өргөдөл, гомдол ирээгүй.

		суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.			
Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах					
3.1.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	-Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах; -Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; -Хэрэгжилтийг тайлагнах.	Жилдээ	Цахим үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулсан байна.	Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгын хүрээнд санал асуулгыг боловсруулан харилцагч байгууллагуудад хүргүүлсэн. Харилцагч байгууллагаас ирүүлсэн асуумжид цахим үйлчилгээг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгардаггүй, хүнд суртал, авлигын эрсдэл үүсэх боломжгүй ба боловсронгуй болгох талаар нэг санал ирүүлсэн.
3.2.	Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	-Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших; - Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан хэрэгжүүлсэн байх;	Жилдээ	Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Комплаенсын хяналтын журамд “Шүгэл үлээх” ажиллагааны талаар тусгаж, уг журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар шүгэл үлээсэн тохиолдол гараагүй болно.

3.3.	Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх	-Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх; -Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээ, хэрэгжүүлж буй арга хэмжээ онцлогт тохирсон байх.	Жилдээ	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	
3.3.1	Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг олон нийтэд тогтмол мэдээлэх	Төрийн аудитын байгууллагаас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын тайланг олон нийтэд ил тод мэдээлсэн байх,	Жилдээ	Аудитын тайланг олон нийтэд мэдээлсэн байна.	2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд “Грант торнтон аудит” ХХК-ийн хийсэн хараат бус аудиторын тайлан, дүгнэлтийг www.mongolianre.com цахим хуудсанд нээлттэй байршуулсан.
3.3.2	Байгууллагын хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах;	-Мэдээллийг тухай бүрд нь шинэчлэх; -Тайланд шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Мэдээллийг байгууллагын цахим хуудаст ил тод мэдээлсэн байна.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг www.mongolianre.com цахим хуудсанд бүрэн байршуулж, мэдээллийг тогтмол шинэчилж байна.
3.3.3	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг хийж үр дүнг тооцон ажилласан байх;	-Дотоод хяналт шалгалтыг хийсэн байх; -Дотоод хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Дотоод хяналт шалгалтыг хийж, үр дүнг тооцсон байна.	-Дотоод хяналт шалгалтын ажилтан зудын гамшгаас шалтгаалж өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан орон нутагт ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж

					ажилласан. Мөн УИХ-ын 2024.04.19-ны өдөр баталсан “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон МУЗГ-ын 2024.04.24-ний өдрийн №166 тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий ач холбогдол, үр нөлөөг иргэд малчдад сурталчлан таниулах ажилд томилогдон хөдөө, орон нутагт үргэлжлүүлэн ажиллаж буй учир төлөвлөгөөт дотоод хяналтын ажил хойшлогдсон. -Хувийн зорилгоор компанийн нэрийг ашигласан, хууль, дүрэм журмаар өөрт олгогдоогүй эрх мэдлийг хэрэгжүүлсэн үйлдлийг шалгаж тогтоон, тайлан дүгнэлтийг харьяалах удирдлагад нь шилжүүлсэн.
--	--	--	--	--	---

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК